



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БТГ	Байнгын төлөөлөгчийн газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГХС	Гадаад харилцааны сайд
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЕКГ	Ерөнхий консулын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТХН	Төсөл хөтөлбөрийн нэгж
УБХТГ	Улаанбаатар хотын худалдааны төлөөлөгчийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭСЯ	Элчин сайдын яам



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	9
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар .....	10
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	10
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	13
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал.....	14
3.1	Зардлын данстай холбоотой асуудал .....	14
3.2	Зарлагын данстай холбоотой асуудал .....	15
3.3	Зардлын данстай холбоотой асуудал .....	15
3.4	Зардлын данстай холбоотой асуудал .....	16
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	17
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	18
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
5.	Хавсралт .....	23
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23



ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД  
Д.ЦОГТБААТАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 849  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ







## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Цогтбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хариуцан гүйцэтгэв.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 04 дугаар сарын 04-ний өдрийн 08/1878 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим, сорилыг гүйцэтгэн, үе шатны чанарын хяналтыг хийлгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

ГХЯ-ны эрхэм зорилгыг “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчинг бүрдүүлэх, дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор ГХЯ-ны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дах монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;



- Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын удирдлага болон төсвийн ерөнхийлөн захирагч дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Дипломат албаны тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг<sup>1</sup> нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ГХЯ-ны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлж аудитад мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашигласан байна.

ГХЯ-ны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

ГХЯ-ны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

ГХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас тайлант онд нийт 28 ажил, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж нийт 28 танилцуулга боловсруулж, 120

<sup>1</sup> Гадаад харилцааны сайдын тушаалаар батлагдсан





гаруй зөвлөмж өгч, хяналт шинжилгээ, санхүү, дотоод аудитын чиглэлээр ТНБД-ын 3 албан даалгаврыг ГХЯ-ны газар нэгж, ДТГ-уудад хүргүүлж ажилласан байна.

Тайлант онд ГХЯ-ны дотоод аудитын албанаас батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээнээс товч дурдвал:

- Вашингтон дах ЭСЯ, Нью-Йорк дах БТГ, Сан Франциско, Хөх хот, Эрхүү, Улаан-Үүд дэх ЕКГ-уудад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид зөрчилгүй ажиллах талаар холбогдох газруудад зөвлөмж өгч, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын зааварлах захидлыг боловсруулж нийт ДТГ-т хүргүүлсэн, ҮАГ-аас хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах тал дээр санаачлагатай ажиллаж ДТГ-аас биелэлтийг гаргуулж үр дүнг тооцсон;

- “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2018 онд 42 ДТГ-т хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг яамны удирдлагад танилцуулан ДТГ-уудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан бөгөөд хуулийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн;

- ГХС-ын 2017 оны тушаалын хэрэгжилтийн явц, Иргэдэд туслах сангийн 2016-2017 оны үйл ажиллагаа, ГХЯ-ны 2017, 2018 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаа, 2017-2018 оны дипломат болон албан паспорт олголт, үнэт цаасны зарцуулалт зэрэг асуудлуудад дотоод аудитыг гүйцэтгэж, дүнг Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, зөвлөмж гарган биелэлтийг хэрэгжүүлж ажилласан байна.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн дүн өмнөх оноос 6,359.5 сая төгрөг буюу 29.8 хувиар буурсан нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад ГХС-ын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.



Материаллаг байдлын суурийг сонгохдоо төлөвлөлтийн үе шатанд эрсдэлийг үнэлж үзэхэд зардлын дансанд эрсдэл их байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 132,942.5 сая төгрөгийн 2 хувиар буюу 2,658.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь ГХЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт үр нөлөөтэй, санхүүгийн бүртгэл, тайлагналын үйл ажиллагааг эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төлөвлөлтийн үе шатанд аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг тодорхойлсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг үнэлж, баримтжуулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний ТШЗ-3, ТТЗ-1, ТӨҮГ-1, ТХН-1, ЗГТС-2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Хүснэгт 1 (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр, тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	1		
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	1			
3	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1			
4	Засгийн газрын тусгай сан		2		
5	Төсөл хөтөлбөрийн нэгж				1
6	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>3</b>		<b>1</b>

Эх сурвалж: МУЕА-ын 2018 оны 156 дугаар тушаал

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагын санхүүгийн тайланд Төрийн аудитын байгууллага, 1 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын компани гэрээгээр аудит хийж тус тус “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 14.610.1 сая төгрөгийн 35 алдаа, зөрчил илрүүлснээс 89.6 хувь буюу 13,091.4 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 3.5 хувь буюу 512.1 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 2.2 хувь буюу 324.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 4.7 хувь буюу 682.6 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитын явцад санхүүгийн тайланд хийлгэсэн залруулгын талаарх мэдээлэл:



Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлуудыг холбогдох төсвийн захирагчдаар хүлээн зөвшөөрүүлж, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно. Үүнд:

- ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 144.3 сая төгрөгийн
- ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд 2,055.7 сая төгрөгийн
- ДБҮЭГ-ын санхүүгийн тайланд 10,891.4 сая, системийн хэмжээнд нийт 13,091.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад тус тус залруулсан болно.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 (Алдаа зөрчил, түүний шийдвэрлэлт, сая төгрөг)

Д/Д	Төсвийн захирагчийн ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	6	199.2	1	0.3	1	105.7	3	93.2
	ТТЗ	6	1,039.2	2	505.0	1	210.7	3	323.5
3	ТӨҮГ	9	159.6	2	6.8	2	7.6	6	145.2
4	ТЕЗ	4	120.7					4	120.7
<b>Нийт дүн</b>		<b>25</b>	<b>1,518.7</b>	<b>5</b>	<b>512.1</b>	<b>4</b>	<b>324.0</b>	<b>17</b>	<b>682.6</b>

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

### 2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг тоймлон харуулбал:

1. ГХЯ-ны аппарат, Юнеско-ийн Монголын үндэсний комиссын хүрээнд нийт 199.2 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс залруулагдаагүй 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 105.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 93.2 сая төгрөгийн алдааг засах 3 зөвлөмж;

2. Дипломат төлөөлөгчийн газрын хүрээнд нийт 3,094.9 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 2,055.7 сая төгрөгийн 3 алдааг залруулж, залруулагдаагүй 505.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 210.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 323.5 сая төгрөгийн алдааг засах 3 зөвлөмж;

3. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-т хийсэн аудитаар нийт 11,051.0 сая төгрөгийн 20 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10,891.4 сая төгрөгийн 11 алдааг залруулж, залруулагдаагүй 6.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 7.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 145.2 сая төгрөгийн алдааг засах 6 зөвлөмж өгсөн.

### 2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.



Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцохоор шийдвэрлэлээ.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгасан болно.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дараагийн аудитаар авч үзэх асуудлын Төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Монгол Улсын ЭСЯ-наас 2008 онд барилга бариулахаар ТОО “ПСК Меген” компанид 576.3 мянган ам.долларыг шилжүүлсэн бөгөөд газар эзэмших асуудлыг шийдвэрлээгүйн улмаас маргаан үүсэж, зардал гарган барилга барьж байсан байршилд бус өөр газарт барилгаа барьж ашиглалтад оруулжээ.

Төрийн өмчийн хорооны 2011 оны 634 дүгээр тогтоолоор дээрх компанид шилжүүлсэн төлбөрийг буцаан авч, хохирлыг барагдуулах асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхийг ГХЯ-нд даалгасан боловч хэрэгжүүлж чадаагүй өнөөг хүрсэн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

2. ГХЯ-ны санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга угсралтын ажил дуусаж 2017 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан боловч анхны гүйцэтгэгч болох “Хөмотэ” ХХК-тай барилгын гүйцэтгэлийн талаар маргаан үүсгэсэн шүүхийн асуудал эцэслэгдээгүй асуудлыг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардалд 69,930.8 сая, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 1,800.0 сая төгрөг, нийт 71,730.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 57,992.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтанд 1,800.0 сая төгрөгийн санхүүжилт авч нийт дүнгээрээ 99.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын урсгал зардал 59,469.5 сая төгрөг буюу 85.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах шалтгаануудтай холбоотой байна. Үүнд:

- ГХЯ-ны төв аппаратын хувьд мэдээлэл, технологийн үйлчилгээний зардалд 990.0 сая төгрөг батлагдсаныг зарцуулаагүй, олон улсын байгууллагад төлөх гишүүний татвар 1,702.8 сая төгрөг, гадаад сурталчилгааны зардал 76.2 сая төгрөг, тэтгэвэрт



гарах ажилтнууд үргэлжлүүлэн ажиллаж байгаагаас нэг удаагийн мөнгөн тэтгэмж 148.8 сая, Засгийн газар хоорондын комиссын хуралдааны зардал 38.6 сая төгрөг батлагдсаныг зарцуулаагүй, гадаад томилолт, зочны зардал 80.2 сая төгрөг, байр ашиглалтын холбоотой тогтмол зардал 23.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн.

- ДТГ-ын хувьд Шанхай дах ЕКГ, Манжуур дах КГ-ын 2018 оны урсгал зардалд 1,629.9 сая төгрөг батлагдсан боловч КГ-уудын зөвшөөрөл хүлээгдэн нээгдээгүйгээс уг зардал зарцуулагдаагүй, 9 ДТГ-ын цалин тогтоох нэгжийг 2018 онд нэмэгдүүлэхээр төсөвлөж байсан нь 2019 оны 01 сарын 01-нээс хэрэгжсэнтэй холбоотой 617.5 сая төгрөг, ажилтнуудын тоо, гэр бүлийн гишүүний тооноос хамаарч цалин, нийгмийн даатгалын шимтгэл 700.0 сая төгрөг, байрны түрээс 500.0 сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 883.7 сая төгрөг, хичээл сургалтын зардал 697.0 сая төгрөг, тэтгэвэрт гарах ажилтнууд үргэлжлүүлэн ажиллаж байгаагаас нэг удаагийн мөнгөн тэтгэмж 339.8 сая төгрөгөөр тус тус зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар Нийслэлийн төсвөөс Тайпей дэх УБХТГ-ын 637.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч холбогдох газарт шилжүүлсэн байна.

Мөн Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 108 дугаар тушаалын дагуу Засгийн газрын нөөц сангаас ГХЯ-ны ДТГ-ын дансанд байршуулсан 315.3 сая төгрөгийг тайлант оны эцэст улсын төсөвт буцаан төвлөрүүлснийг Сангийн яамтай буцааж авах авлагаар тооцоо нийлж бүртгэсэн байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулах, хуулийг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

ГХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны 2018 оны ажлын тайланд дурдсанаар ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 4 удаа хяналт, үнэлгээ хийж тухай бүрд нь холбогдох заавар зөвлөмжийг хүргүүлж ажилласны үр дүнд Шилэн дансны цахим мэдээллийн санд хуулийн хугацаанд нь байршуулсан мэдээлэл 22.2 хувиар өсөж, хугацаа хоцорсон мэдээлэл 15.7 хувиар, байршуулаагүй мэдээлэл 8.0 хувиар тус тус буурсан байна.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 98.5 хувийн биелэлттэй гарсан нь өмнөх онтой харьцуулахад 10.8 хувиар сайжирсан байна гэсэн дүгнэлт өгсөн байна.

Тайлант онд Авлигатай тэмцэх газрын шударга байдлын үнэлгээний урьдчилсан дүнгээр ГХЯ 100 онооноос 80.2 оноо авч төрийн захиргааны төв байгууллагуудаас хамгийн сайн үнэлгээний дүн үзүүлсэн байна.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай” хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг “хангалттай” гэж үзлээ.





## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 33 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд 28 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 5 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу нийт 94.4 хувийн биелэлттэй гарсан байна.

ТНБД-ын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн “Санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 13/1371 дүгээр зааварлах захидлыг нийт Дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

